

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН, МАТАД СУМДАД ХУДАГ, УСТ ЦЭГ,
ЦООНОГ ГАРГАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2018.02.25

Хэрлэн сум

1 Байршил:

1.1. Матад сум

- 1.1.1. Эрдэнэбадрах баг Тойром X 115°55'26.60", У 46°55'4.97"
- 1.1.2. Баянхангай баг Зах толгой X 115°36.45", У 46°35.21"
- 1.1.3. Баянхангай баг Улаан-Өндөрийн ар X 114°44'32.8", У 46°50'18.4"
- 1.1.4. Буян-Өндөр баг Баянтолгой X 115°52'11.4", У 47°20'31"
- 1.1.5. Буян-Өндөр баг Шар худаг X 115°38'9.6", У 47°61'45"
- 1.1.6. Түмэн хан баг Энх хөндий X 115°21'6.6", У 46°58'38.1"

1.2. Хэрлэн сум

- 1.2.1. Баянтүмэн сумын 3 дугаар баг Тагийн тойрмын Өргөө толгой X 114°50'35", У 48°41'14.
- 1.2.2. Чойбалсан сум Сүмбэр баг Хонхор шүүтийн баруун дэнж X 117°47'24", У 48°17'49.

2. Тавигдах шаардлага:

Уст цэг, цооног гаргах ажлыг “Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага” MNS 6088:2010 стандартын дагуу “Усны мэргэжлийн байгууллага” хийж гүйцэтгэнэ.

№	Үзүүлэлтүүд
1. Цооног өрөмдөх, цооногийг тоноглох	
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтооно.
1.2	Өрөмдмөл худгийн цооногийн ашиглалтын ундарга нэг цагт 2 м ³ -ээс 6 м ³ ус өгөх хүчин чадалтай байна.
1.3	Суултын болон шүүрийн яндангийн материал нь ган буюу зөвшөөрөгдсөн хуванцар яндан байна.
1.4	Ус өргөх ган буюу зөвшөөрөгдсөн хуванцар яндангийн диаметр 32 мм байна.
1.5	Цооног дахь суултын яндан, шүүр нь 20-оос доошгүй жил ашиглах нөхцлийг хангасан байвал зохино.
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 9 мм –ээс томгүй байна.
1.7	Худгийн шавхалт хийх хугацаа 24 цаг байна.
1.8	Худгийн уснаас дээж авч шинжилгээ хийлгэсэн байна.
1.9	Худгийг түр хугацааны тагаар тоноглох шаардлагатай.
2. Худгийн насос, цахилгааны утас, хянах самбар	
3.1	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан. Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байна. Гарал үүслийн гэрчилгээтэй,

	үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байна.
3.2	Цахилгааны утас нь худагт ашиглах шаардлагыг хангасан 3 фазын, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн (залгаасгүй), ус өргөх янданд 2м тутамд хавчиж тогтооно.
3.3	Хянах самбар нь асаах, унтраах товчлууртай байна. Насос ажиллаагүй байх үед ногоон гэрэл, хүчдэл өгч ажиллаж байх үед улаан гэрэл асаж байхаар тохируулна.
3. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх	
4.1	Талбайг цэвэрлэнэ. /өрөмдлөгийн шлам, цементний баглаа боодол, хайрга чулуу болон ахуйн хог хаягдал гм/
4.2	Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах талбайн сургалтыг худаг ашиглагч нарт хийнэ.
4.3	Худгийн паспортыг бэлтгэж, баталгаажуулан сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэж өгнө.

Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам” –ыг мөрдөнө.

